



**"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан**

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК нь Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу 2022 оны 12 дугаар сард нэмэлт хувьцаагаа олон нийтэд санал болгон нээлттэй арилжин нийт 11.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн билээ.

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаар үнэт цаасны танилцуулгад тодорхой тусгасан бөгөөд компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулахаар төлөвлөсөн болно.

Д/д	Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө	Хувь
1	Арилжааны систем сайжруулалт	63.7%
2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал	10.7%
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	6.1%
4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох	19.5%
<b>Нийт</b>		<b>100%</b>

Компани 2023 онд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 6.0 тэрбум төгрөгийн зарцуулалт хийхээр төлөвлөсөн бөгөөд үүнд:

- Мэдээлэл технологийн шинэчлэл сайжруулалт болон Хөрөнгийн зах зээлийн сургалт, үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгоход нийт 4.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөсөн болно. Үүнээс MIT программ хангамжийн шинэчлэлд зориулах 3.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтад MIT системийн түүхий эд болон деривативын арилжааны модуль, IPO системийн шинэчлэл, МХБ-ийн дотоод үйл ажиллагааны автоматжуулалт, дагалдах өгөгдлийн сангийн лицензүүд багтсан;

- Арилжааны дэд бүтэц болох MIT системийн жилийн үйлчилгээний зардалд ЛХБ групптэй байгуулсан "Лиценз, засвар үйлчилгээний гэрээ"-ний дагуу 2023 онд 1.1 тэрбум төгрөг төлөхөөр тусгагдсан болно.

Татан төвлөрүүлсэн хөрөнгө зарцуулалтын тайланг 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар танилцуулбал:

*Мянган төг*

№	Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө	Төлөвлөгөө		Хэрэгжилт		Тайлбар, тодруулга
		Хувь	Мөнгөн дүн	Хувь	Мөнгөн дүн	
1	Арилжааны системийн сайжруулалт	63.70%	7,590,339.0	0.17%	20,000.0	Нүүрсний спот арилжаа платформ
				1.94%	230,817.5	MIT системийн 2023 оны I улирлын үйлчилгээний төлбөр
Нийт 1				2.10%	250,817.5	

2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал	10.70%	1,274,986.3	-	-
Нийт 2				-	-
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	6.10%	726,861.4	-	-
Нийт 3				-	-
4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох	19.50%	2,323,573.2	-	-
Нийт 4				-	-
Нийт		100%	11,915,759.8	2.10%	250,817.5

2023 онд зарцуулах татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээг худалдаж авах ажиллагаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу үе шаттайгаар хэрэгжиж байгаа болно.

Тайлан бэлтгэсэн: Захиргаа, санхүүгийн газар

